“ ЭБЦТС“ ТӨХК-ИЙ БУЛГАНЫ САЛБАР

БАТЛАВ

АХЛАХ ИНЖЕНЕР Г.ОТГОНБАЯР

2018 оны 02 сарын 24

Техникийн нохцөл № 05/2018

1. Хэрэглэгчийн нэр, хаяг: Хөвсгөл аймаг Тариалан сум
2. Ажил үйлчилгээний зориулалт: цахилгаан хангамж өргөтгөл шинэчлэл
3. Техникийн нөхцөл олгох үндэслэл:Өргөдөл, тодруулах хуудас
4. Тусгай заалтууд:

   А. Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай тоног төхөөрөмж суурилуулах.

   Б. “Эрчим хүчний тухай хууль”-ийн 30.1.10-д заасны дагуу Түгээх, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах үүрэгтэй.

   В. Энэхүү техникийн нөхцлийн дагуу тавигдах тоноглолууд, шугам нь шинэ тоноглол байх шаардлагатай.

   Г. Угсралтын ажлын явцад ЭБЦТС ТӨХК-ий Булган салбараар хяналт, тавиулж холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн байх.
5. Холбогдох цэг: Тариалан сумын АТП-3, 4-р дэд станцын 1, 2-р гаргалгаа. 0.22 кВ 0.4 кВ-н ЦДАШ-г төмөр бетон тулгуур сип кабель болгох.
6. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:
   6.1. 0.4 кВ-ын ЦДАШ-ын байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн, Барилга хот байгуулалт, төлөвлөлтийн газраар батлуулж схем холболт, хүчин чадлыг Булган салбараар хянуулах.
   6.2.Шугамын трасс, хамгаалалтын зурваст барилга барих, ажил, үйлчилгээ явуулахыг хориглоно.
   6.3.Барилга доторхи щитний газардуулгыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж, проткол авсан байх.
   6.4.Цахилгаан угсралтын ажлыг мэргэжлийн байгууллагаар Аюулгүй Ажиллагааны Дүрэм болон Техник ашиглалтын дүрэм дагуу гүйцэтгүүлэх.
   6.5.Хүчдлийн түвшингийн ±5%-ийн хэлбэлзлэлд зохицсон тоноглол суурилуулах.
   6.6.Засгийн газрын 2001 оны 263 тоот тогтоолоор батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн заалтыг мөрдлөг болгох.
   6.7.“Эрчим хүчний тухай хууль”-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнга үзлэг шалгалт хийх. Хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх.
   6.8.Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний

хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

6.9.“Эрчим хүчний тухай хууль”-ийн болон “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн заалтуудыг дагаж мөрдөх

6.10. Цахилгаан эрчим хүчний тооцоог ЭБЦТС ТӨХК-ий Булган салбарын эрчим хүч борлуулах хэсэгтэй хийх.

6.11. Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 2 жилийн хугацаанд хийж, гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:
“ЭБЦТС” ТӨХК-БУЛГАН САЛБАРЫН АШИГЛАЛТЫН
ИНЖЕНЕР Л.САРУУЛБАЯР